ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХУУЛЬ, ЖУРАМД ЗААГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: "ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН"**

**АУДИТЫН КОД: ДАА-2022/30-6-ШТА-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**
Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
**Ахлах аудитор У.Батсүрэн**
Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
**Аудитор С.Санжаажав**
Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn
**Аудитор Г.Батмягмар**
Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn



Дархан-Уул аймаг
2022 он

# АГУУЛГА


Аудитын тайлан баталгаажуулсан тушаал …………………………………………..…………3

Товчилсон үгийн тайлбар…………………………………………………………………….…5

Хүснэгтийн товьёг……………………………………………………………………………...……6

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл…………….…………7

БҮЛЭГ 1. ОНХС-ийн эх үүсвэрт малын тоо, толгойн албан татварын орлогыг тооцож төлөвлөөгүй байна……………………………………………………………………..……………..8

*1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлжээ* ……………………………………………………………………………………8

*1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн батлагдсан хуваарийг баримтлаагүй ч санхүүжилтийг бүрэн олгожээ* ………………………………………………..8

*1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна* ……………………………………………………………………………………9

*1.1.4. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс өөр эх үүсвэрийг судалж, төлөвлөөгүй байна* ……………………………………..10

*1.2.1. ОНХС-ийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй байна* ………………………………………..........................................................…..11

*1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ* ......................................12

*1.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд заагдаагүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ* ...........................................................13

БҮЛЭГ 2. Хууль, журамд заагаагүй 7 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд 33.3 сая төгрөг зарцуулжээ 14

*2.1.1 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй байна* 14

*2.1.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд нийцээгүй 33.3 сая төгрөгийн 7 ТАХ санхүүжүүлсэн байна* 15

*2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 78.3 хувийн гүйцэтгэлтэй байна* 16

*2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ-г хэрэгжүүлсэн байна* 17

*2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын агуулахад хадгалаагүйгээс эвдрэл, гэмтэл үүсэх, алдагдах эрсдэлтэй байна* 19

БҮЛЭГ 3. Захиалагчийн хяналт сул байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна 20

*3.1.1. Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.* 20

*3.1.2. Захиалагчийн хяналт сул байгаагаас зарим хөрөнгө оруулалтын ажлууд зураг, төсвийн дагуу, чанартай хийгдээгүй байна* 20

*3.1.3. Өмнөх аудитын шалгалтаар илэрсэн алдаа зөрчил давтагдан гарч, зөрчлийн хэмжээ буурахгүй байна* 21

*3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнажээ* 22

*3.2.2. Дархан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 тохижилтын ажлыг бүртгэлд тусгаагүй байна* 22

*3.2.3. Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл оруулах ажил хангалтгүй байна* 23

*3.2.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан хуулийн этгээд санхүүжилтийн мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй байна* 23

Холбогдох байгууллагаас ирсэн санал: 25

Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналыг тайланд тусгасан тэмдэглэл: 35

ДҮГНЭЛТ: 41

ЗӨВЛӨМЖ: 42

## Аудитын тайлан баталгаажуулсан тушаал

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 09 өдөр Дугаар А/11 Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар батлсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Дархан сумын Засаг дарга, Шарын гол сумын Засаг дарга, Хонгор сумын Засаг дарга, Орхон сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/, Дархан сумын Засаг дарга /Т.Тулгаа/, Шарын гол сумын Засаг дарга /Б.Лхамсүрэн/, Орхон сумын Засаг дарга /Б.Алтансарнай/, Хонгор сумын Засаг дарга /Т.Атархишиг/, Орон нутгийн өмчийн газар /Б.Баасанжаргал/, “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ /Д.Батбаяр/-т зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг /аудитор С.Санжаажав/-т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /У.Батсүрэн/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

D:\Бичиг хэрэг\Тушаал.docx

009010032

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 21/19 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

/мянган төгрөг/

| № | Төлбөр, зөрчил хариуцах байгууллага | Зөрчлийн товч утга | Дугаар | Албан шаардлагын дүн |
|---|---|---|---|---|
| 1 | “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ | ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн “Дархан сумын 9, 10, 11, 12 дугаар багийн гудамж, зам талбайн гэрэлтүүлэг”, “Шинэ хуучин Дарханыг холбосон авто замаас 27 дугаар байрны дэргэдэх дөрвөн замын уулзвар хүртэлх авто зам дагуух гэрэлтүүлэг”, “Төв замаас Орхон сумын төв хүртэлх 11 км засмал зам засвар”ын ажлын хэрэгжилтэд захиалагчийн хяналт хангалттай хэрэгжүүлээгүйгээс зураг, төсвийн дагуу хийгээгүй, чанарын шаардлага хангаагүйгээс эвдрэл үүссэн байна. | 01/46/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | |
| 2 | Аймгийн ЗДТГ, ХБТХОХ | “Хустайн шил” ХХК аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр шинэ хуучин Дарханыг холбосон авто замаас 27 дугаар байрны дэргэдэх дөрвөн замын уулзвар хүртэлх авто зам дагуух гэрэлтүүлгийн шонгийн тэгшилгээг стандартын дагуу хийгээгүй | 02/55/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | |
| 3 | Аймгийн ЗДТГ, ХБТХОХ | Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Дархан сумын 9, 10, 11, 12 дугаар багийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэсэн “Ингүүмэл эрчим” ХХК гэрлийн шонгийн суурийг зураг, төсвийн дагуу зориулалтын бетон сууриар хийгээгүй. | 03/56/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | |
| 4 | Аймгийн ЗДТГ, ХБТХОХ | Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр иргэн С.Баянмөнх Дархан сумын 10-р багт 19,991,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй гадна зам талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд баталгаат хугацаанд хүүхдийн тоглоом эвдэрч ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. | 04/57/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | |
| 5 | Орхон сумын ЗДТГ | Орхон сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн 20,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй Орхон сумын авто зам засварын нөхөөсний ажил ихэнх хэсэгтээ эвдрэл үүссэн байгаа бөгөөд гэрээний заалт болон гүйцэтгэгчийн гаргасан чанарын баталгааны дагуу “Билигт инженеринг” ХХК-аар засвар үйлчилгээ хийлгээгүй байна. | 05/58/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | |
| | Дархан сумын ЗДТГ | Дархан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн тус бүр нь 10,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй “Бидний орчин”, “Гэрэлтүүлэг” төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. | 06/59/А0970289/ДАА-2022/30-6-ШТА-ГА | 20,000.0 |
| | **Нийт** | | | **20,000.0** |

ХТ06430@9022899

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АДБОУБ | Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны татвар |
| ДХББЗГ | Дархан-хот байгуулалт, барилга захиалагчийн газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын газар |
| ЗТХС | Зам, тээвэр хөгжлийн сайд |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИНХ | Иргэдийн нийтийн хурал |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НААҮГ | Нийтийн аж ахуй үйлчилгээний газар |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТЭЗҮ | Техник, эдийн засгийн үндэслэл |
| УМС | Удирдлагын мэдээллийн сан |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХБТХОХ | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| ХХК | Хязгаарлагдмал хувьцаат компани |

## Хүснэгтийн товъёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| ***Хүснэгт №1*** | *Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл* | *7* |
| ***Хүснэгт №2*** | *ОНХНС-аас олгосон санхүүжилт* | *8* |
| ***Хүснэгт №3*** | *Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарь, гүйцэтгэл* | *8* |
| ***Хүснэгт №4*** | *Аймаг, сумдын ОНХС-ийн орлогын төлөвлөгөө* | *9* |
| ***Хүснэгт №5*** | *Хэрэгжүүлсэн ТАХ, олгосон санхүүжилт* | *15* |


## Зургийн товъёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| ***Дүрслэл №1*** | *Аймгийн хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо* | *11* |
| ***Дүрслэл №2*** | *Хэрэгжүүлсэн ТАХ-г ангилж харуулсан* | *17* |
| ***Дүрслэл №3*** | *Алдаа, зөрчлийн өсөлтийг ангилж харуулав* | *21* |

| | |
|---|---|
| | **Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл** |
| **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх** | Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамж, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугээр зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв. |
| **Аудитын зорилт** | ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.<br>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>• ОНХС-ийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;<br>• ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;<br>• ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх. |
| **Аудитын хамарсан хүрээ** | Аудитад аймаг, сумдын ОНХС-ийн 2021 оны үйл ажиллагаа болон бусад байгууллагууд хамарсан болно. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитыг АДБОУБ-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит", MNS 6817-8:2020 "Төрийн аудит. Нийцлийн аудит"-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МУЕА-ын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. |
| **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа** | Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор У.Батсүрэн хэрэгжүүлж, аудитор С.Санжаажав, Г.Батмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв. |

## БҮЛЭГ 1. ОНХС-ийн эх үүсвэрт малын тоо, толгойн албан татварын орлогыг тооцож төлөвлөөгүй байна

### *1.1.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлжээ*

Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд тухайн орон нутгийн иргэд, олон нийтийн саналыг тусгах, оролцоог хангахад чиглэгдсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар ОНХНС-ийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан эх үүсвэрээс Дархан-Уул аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 8,676.2 сая төгрөгөөр төлөвлөж, баталжээ.

Мөн ОНХНС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, ОНХС-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг урамшуулах замаар "Тогтвортой амьжиргаа-3" төслөөс 313.1 сая төгрөгийн урамшуулал, 117.0 сая төгрөгийн дэмжлэг олгохоор төлөвлөж, бүрдүүлсэн байна.

**Хүснэгт 1:** Орлогын эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл.

*/Сая.төгрөгөөр/*

| № | Орлогын эх үүсвэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | АМНАТ | 2,875.5 | 2,875.5 |
| 2 | Дотоодын НӨАТ | 1,425.3 | 1,425.3 |
| 3 | Газрын тосны нөөц ашигласны төлбөр | 264.7 | 264.7 |
| 4 | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | 7.8 | 7.8 |
| 5 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 76.8 | 76.8 |
| 6 | АМНАТ-Мега төсөл | 3,596.0 | 3,596.0 |
| 7 | Тогтвортой амжиргаа 3 төслөөс-Урамшуулал | 313.1 | 313.1 |
| | Тогтвортой амжиргаа 3 төслөөс-Дэмжлэг | 117.0 | 117.0 |
| | **Дүн** | **8,676.2** | **8,676.2** |

*Эх сурвалж: Сангийн яам, аймгийн СТСХ*

Тайлант онд ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг гүйцэтгэлээр 8,676.2 сая төгрөг болж өнгөрсөн оноос 21.2 хувиар өссөн нь орлогын өсөлттэй холбоотой байна.

### *1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн батлагдсан хуваарийг баримтлаагүй ч санхүүжилтийг бүрэн олгожээ*

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн тооцсон байна.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс аймагт олгох орлогын шилжүүлгийг 8,430.1 сая, үүнээс урсгал зарлагыг 1,025.1 сая төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 2.9 хувиар нэмэгдүүлж 8,676.2 сая төгрөгөөр баталжээ.

**Хүснэгт 2:** ОНХНС-аас олгосон санхүүжилт

| Улирал | Санхүүжилт /сая.төг/ | | Зөрүү |
|---|---|---|---|
| | Төсвийн хуваарь | Гүйцэтгэл | |
| I | 992.6 | 325.3 | (667.3) |
| II | 1,946.2 | 2,040.4 | 94.2 |
| III | 2,043.3 | 3,413.0 | 1,369.7 |
| IV | 3,694.1 | 2,897.4 | (796.7) |
| **Дүн** | **8,676.2** | **8,676.2** | **(0.0)** |

*Эх сурвалж: Сангийн яам*

Хүснэгтээс үзэхэд ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу олгоогүй боловч, батлагдсан аргачлалын дагуу тооцож, санхүүжилтийг бүрэн олгожээ.

### *1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна*

Аймгийн ОНХС-ийн 2021 оны төсвийн хуваарийг аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/04 тоот захирамжаар баталсныг 2021 оны 01-А/291 тоот захирамжаар 166.7 сая, 01-А/366 тоот захирамжаар 9.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

**Хүснэгт 3:** Аймгийн ОНХС-аас сумдын олгох орлогын шилжүүлгийн хуваарь, хуваарьт орсон өөрчлөлт, гүйцэтгэл

| Улирал | Сумын нэр | Санхүүжилт /сая.төг/ | | | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| | | Анх батлан хуваарь | Шинэчилсэн хуваарь 2021.10.15 | Шинэчилсэн хуваарь 2021.12.16 | Гүйцэтгэл | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7=6-5 |
| I | Дархан | 20.0 | 20.0 | 20.0 | - | (20.0) |
| | Орхон | 10.0 | 10.0 | 10.0 | - | (10.0) |
| | Хонгор | 70.0 | 70.0 | 70.0 | - | (70.0) |
| | Шарын гол | 10.0 | 10.0 | 10.0 | - | (10.0) |
| II | Дархан | 293.5 | 293.5 | 293.5 | 243.1 | (50.4) |
| | Орхон | 110.5 | 118.0 | 118.0 | - | (118.0) |
| | Хонгор | 375.4 | 530.5 | 530.5 | 77.0 | (453.5) |
| | Шарын гол | 152.5 | 156.5 | 156.5 | 23.4 | (133.1) |
| III | Дархан | 120.0 | 120.0 | 129.2 | - | (129.2) |
| | Орхон | 60.0 | 60.0 | 60.0 | 116.5 | 56.5 |
| | Хонгор | 190.0 | 190.0 | 190.0 | 454.9 | 264.9 |
| | Шарын гол | 150.0 | 150.0 | 150.0 | 320.5 | 170.5 |
| IV | Дархан | 242.4 | 242.4 | 242.4 | 323.1 | 80.7 |
| | Орхон | 100.6 | 100.6 | 100.6 | 15.8 | (84.8) |
| | Хонгор | 709.3 | 709.3 | 709.3 | 533.5 | (175.8) |
| | Шарын гол | 291.6 | 291.6 | 291.6 | 252.8 | (38.8) |
| | **Дүн** | **2,905.8** | **3,072.5** | **3,081.7** | **2,360.6** | **(721.1)** |

*Эх сурвалж: Аймгийн СТСХ*

Хүснэгтээс харахад батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт олгогдоогүй бөгөөд жилийн дүнгээр 721.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 10.2.5-д "Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын

2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

### *1.1.4. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгээс өөр эх үүсвэрийг судалж, төлөвлөөгүй байна*

Аймаг, сумдын 2021 оны ОНХС-ийн эх үүсвэрийг судалж үзэхэд дараах байдлаар төлөвлөсөн байна.

**Хүснэгт 4:** Аймаг, сумдын ОНХС-ийн орлогын төлөвлөгөө

| Аймаг, сум | Орлогын эх үүсвэр | Төлөвлөгөө /сая.төг/ |
|---|---|---|
| **Дархан-Уул аймаг** | Өмнөх оны үлдэгдэл | 390.5 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 4,887.8 |
| | **Дүн** | **5,278.3** |
| **Дархан сум** | Өмнөх оны үлдэгдэл | 50.4 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 634.6 |
| | **Дүн** | **685.1** |
| **Орхон сум** | Өмнөх оны үлдэгдэл | 7.5 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 281.1 |
| | **Дүн** | **288.6** |
| **Хонгор сум** | Өмнөх оны үлдэгдэл | 256.5 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 1,243.4 |
| | **Дүн** | **1,499.9** |
| **Шарын гол сум** | Өмнөх оны үлдэгдэл | 4.0 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 604.1 |
| | **Дүн** | **608.1** |
| **Аймгийн дүнгээр** | Өмнөх оны үлдэгдэл | 709.0 |
| | ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг | 7,651.0 |
| | **Нийт дүн** | **8,360.0** |

*Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол*

Дээрх хүснэгтээс харахад ОНХНС болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг, өмнөх оны үлдэгдэл гэсэн 2 эх үүсвэрээс санхүүжихээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасантай нийцэхгүй байна.

Тухайлбал хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4[1], 60.2.5[2], 60.2.8[3]-д заасан эх үүсвэрийг тооцоогүй нь төлөвлөлт үндэслэлгүй хийгдэх, дүрэм журам зөрчигдөх эрсдэлтэй юм.

Хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан эх үүсвэр буюу малын тоо толгойн албан татвараас аймгийн дүнгээр 2021 онд нийт 131.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Сумдын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5[4]-д заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн байна.

---

[1] *татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;*

[2] *тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.*

[3] *малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшигаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.*

[4] *4.5. Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд:*
*4.5.1. Бэлчээрийн менежментийг сайжруулах*

### *1.2.1. ОНХС-ийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагаа хангалтгүй байна*

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу сумын Засаг дарга нар захирамж гаргаж төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцуулан аймагт 9, сумдад 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Ажлын хэсэг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөл, урсгал зардлын тооцоолол, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаар дүгнэлт гаргахаар журамд заажээ. Харин аудит хийх хугацаанд ажлын хэсгийн дүгнэлт, тооцооллын баримт, материалыг ирүүлээгүй тул журмын 3.1.7[5]-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд 3,081.7 сая төгрөгийн 111 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө тухайн сум, багийн иргэдээс санал асуулгын хуудас, бүлгийн ярилцлага хийх, цахим гэсэн хэлбэрээр санал авч нэгтгэн ИНХ-аар хэлэлцүүлж, тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг батлуулжээ.

Дархан-Уул аймагт 2021 оны статистикийн тоо мэдээгээр нийт 29,512 өрхөд 104,737 иргэн амьдардаг бөгөөд нийт хүн амын 67.9 хувь буюу 71,116 хөдөлмөрийн насны иргэд байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд иргэдийн оролцоо, идэвхийг хүн амын тоотой харьцуулж дүрслэл №1-ээр харуулав.

---

*4.5.2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх*
*4.5.3. Малын эрүүл мэндийг хамгаалах*
*4.5.4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх*
*4.5.5. Малын чанарыг сайжруулах*
*4.5.6. Гэмт халдлага, гамшгаас хамгаалах*
*4.5.7. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх*
*4.5.8. Малын тэжээлийн ургамал тариалах*
*4.5.9. Тэжээлийн нөөц бүрдүүлэх*
*4.5.10. Байгаль орчныг хамгаалах*
*4.5.11. Хортон мэрэгчидтэй тэмцэх*
*4.5.12. Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа*

[5] *Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах*

**Дүрслэл 1:** Аймгийн хүн амын тоо, ОНХС-д санал өгсөн иргэдийн тоо




| | Хөдөлмөрийн насны хүн амын тоо дунджаар | ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд санал өгсөн иргэд | |
|---|---|---|---|
| | | Тоо | Хувь |
| Шарын гол сум | 5,315 | 1,271 | 23.9 |
| Хонгор сум | 4,050 | 768 | 19.0 |
| Орхон сум | 2,275 | 289 | 12.7 |
| Дархан сум | 59,477 | 4,500 | 7.6 |

Үүнээс үзэхэд хөдөлмөрийн насны иргэдийн 10 хүрэхгүй хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхөд саналаа өгсөн нь иргэд, олон нийтийн ойлголт муу, мэдээлэл дутмаг, идэвх оролцоо хангалтгүй байгаагаас шалтгаалжээ. Тодруулбал иргэдээс авсан санал асуулгын *“Орон нутгийн хөгжлийн сангийн талаар хэр мэдээлэлтэй вэ?”* гэсэн асуултад оролцогчдын 60 хувь нь мэдээлэл хангалтгүй, *“Та энэ үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?”* гэсэн асуултад 62.6 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Энэ нь багийн Засаг дарга нар Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 5.2[6], 5.3[7], 6.4.1[8]-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна

### *1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ*

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2020 оны 2/07 тогтоолоор “Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хүрээнд 7 зорилго, 2/08 тогтоолоор “Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 66 зорилт, 267 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 80 хувь нь нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, авто замын засвар, шинэчлэлт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, дэд бүтэц шинээр бий болгоход чиглэгджээ. Эдгээр нь аймгийн хөгжлийн бодлогын үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

---

[6] *Баг, хорооны түвшинд ОНХС-ийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах*

[7] *Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан жишиг маягтыг баг хорооны өрх бүрд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.*

[8] *Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх*

Харин зарим ТАХ нь байгууллагын урсгал засвар, тоног төхөөрөмж, тавилга худалдан авах зэрэг бага төсөвтэй, олон ТАХ-г хэрэгжүүлэх, мөн хууль журамд заасан чиг үүрэгт нийцээгүй ТАХ-нд зарцуулахаар төлөвлөжээ.

### *1.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд заагдаагүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ*

Аймаг, сумдын Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2[9], 6.5.5[10], 6.5.6[11] дугаар зүйл, 63.1[12], 63.2[13], 63.3[14], 63.4[15] дэх хэсэг, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдлөг болгон ажиллахаар зохицуулсан боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь дээрх хууль, журамд нийцэж байгаа эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Тухайлбал

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Агроэкологи бизнесийн сургуулийн багш нарын төслийн төлбөрт 2.6 сая төгрөг
- Дархан сумын ОНХС-ийн хөрөнгөөр Цагдаагийн газрын амралтын танхим болон зоорийн давхрын засварт 14.0 сая, нийтийн бие засах байрыг нүүлгэн шилжүүлэхэд 5.0 сая, аймгийн Авто тээврийн төвд хүлээлгийн танхимын сандал худалдан авахад 5.0 сая төгрөг
- Хонгор сумын ОНХС-аас цагдаагийн кубон худалдан авах, байцаалтын өрөөний засварт 6.7 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөж, баталжээ.

Энэ нь төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4[16], 60.3.6[17], Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан журмын 3.1.2[18], 4.2.5[19]-д заасантай нийцэхгүй байна. Харин Дархан, Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн оролцоотой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тухайлбал: Дархан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 16 байрны дээвэр засварын ажилд 124.0 сая төгрөгийн санхүүжилтийг 70:30 буюу ОНХС-ийн хөрөнгөөр 70 хувь, тухай орон сууцны оршин суугчдаас 30 хувийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Мөн Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр булаг тохижуулахад 18.5 сая, манай сум, миний гэр төсөлд 15.2 сая, нийт 33.7 сая төгрөгийн 3 төслийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

---

[9] *төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;*
[10] *хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;*
[11] *төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.*
[12] *Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.*
[13] *Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.*
[14] *Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.*
[15] *Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.*
[16] *Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа*
[17] *Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ*
[18] *ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухай орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх*
[19] *Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал*

## БҮЛЭГ 2. Хууль, журамд заагаагүй 7 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд 33.3 сая төгрөг зарцуулжээ

### *2.1.1 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй байна*

Аймгийн хэмжээнд 2021 оны ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнээс нээлттэй тендер 17, харьцуулалтын аргаар 18 нийт 35 ТАХ-г 100 хувь хамруулж, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу тулган баталгаажуулалт хийлээ.

Аудитаар дараах тендерийн үнэлгээний хороог сумдын төсвийн захирагч нар байгуулсан, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцуулдаггүй, бүрэлдэхүүнийг 3 гишүүнтэй байхаар зохион байгуулсан зөрчил илэрлээ. Үүнд:

- Дархан сумын 10-р багт тоглоомын талбай байгуулах ажил
- Нийтийн нойл /морь барианы газар/
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайг камержуулах, дрон худалдан авах ажлууд байна.

Дээрх зөрчлүүд нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1[20], 47 дугаар зүйлийн 47.4-д заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Цаашид сумдын Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар үнэлгээний хороог байгуулж хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөлөл байх нь зүйтэй гэж үзлээ.

Орхон сумын үнэлгээний хорооны зохион байгуулсан 4 тендерээс 3 тендерийн хурлын тэмдэглэл, гаргасан шийдвэр, дүгнэлт байхгүй, "Гал унтраах тусгай зориулалтын машины дулаан гараж барих ажлын баримт бичиг, холбогдох материалууд байхгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.7[21], 49 дүгээр зүйлийн 49.1[22] заалттай нийцэхгүй байна.

Шарын гол, Орхон сумууд тендерийн холбогдох баримт бичгийг архивлахдаа худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тухай товч тодорхойлолт, тендерийн баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг тусгай тээгч (зөөврийн хатуу диск, оптик диск) дээр архивлан хадгалаагүй нь Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох, мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын 8.3-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Цаашид тендерийн холбогдох баримт бичгийг архивлахдаа үнэлгээний хорооноос гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, захиалагчийн тендерийн баримт бичиг, төсөв, техникийн тодорхойлолт, оролцогчдын ирүүлсэн тендерийн баримт

---

*[20] Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, аймаг, нийслэл,* ***сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар*** *нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд;*

*[21] Үнэлгээний хорооноос гаргасан шийдвэр /цаашид "үнэлгээний дүгнэлт" гэх/ нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд хорооны гишүүдийн олонхи дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох бүх мэдээллийг агуулсан байна.*

*[22] Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.*

бичгийг тусгай тээгч (зөөврийн хатуу диск) архивлан хадгалж байх шаардлагатай байна.

ХАА-г зохион байгуулахдаа улирлын болон онцлог шинж чанартай ажлуудыг хугацаа алдаж тендер сонгон шалгаруулалт зарласан, төсвийг зах зээлийн үнийн дүнгээс бага төлөвлөсөн зэргээс шалтгаалан тайлант онд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Хөтөл хорооллын авто замын ажил /Дархан-Уул аймаг/
- Зулзага багийн амралт орчмын зам засврын ажил /Хонгор сум/
- Хустайн давааны засвар, хар бэлчрийн давааны зам засварын ажил /Хонгор сум/
- Салхит багийн нийтийн орон сууцуудад кодтой хаалга хийх /Хонгор сум/
- Гал унтраах тусгай зориулалтын машины дулаан гараж барих /Орхон сум/ ажлууд байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4[23], 46.1.8[24]-д тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой.

Цаашид гүйцэтгэгч тал худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэх ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолт зэргийг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд худалдан авах ажиллагааг зохион байгуулж холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах зэргийг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

### *2.1.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хууль, журамд нийцээгүй 33.3 сая төгрөгийн 7 ТАХ санхүүжүүлсэн байна*

Сангийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11[25], Сангийн сайдын 2018 оны 228, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан чиг үүрэг, үндсэн нөхцөлийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-нд зарцуулахаар зохицуулсан байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 8,360.1 сая төгрөгийн 143 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөсөн 143 ТАХ-ээс бүрэн хэрэгжсэн 101, дутуу 11, огт хэрэгжээгүй 31 ТАХ байна. Тухайн онд бүрэн болон дутуу хэрэгжсэн нийт 112 ТАХ-нд 5,108.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Хүснэгт 5:** Хэрэгжүүлсэн ТАХ, олгосон санхүүжилт

| № | Аймаг, сумын ОНХС | Хөрөнгө оруулалт, ТАХ-ний тоо | Олгосон санхүүжилт /сая.төг/ |
|---|---|---|---|
| 1 | Аймаг | 25 | 2,789.1 |
| 2 | Дархан сум | 41 | 566.1 |
| 3 | Шарын гол сум | 11 | 595.6 |
| 4 | Хонгор сум | 28 | 1,025.1 |
| 5 | Орхон сум | 7 | 132.1 |
| | **Дүн** | **112** | **5,108.0** |

Эдгээрээс Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг зөрчиж, 7 төсөл арга хэмжээнд 33.3 сая төгрөг зарцуулсан байна.

[23] худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;
[24] барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;
[25] *Энэ хуулийн 60.3.6 дахь заалтад 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний зардал хамаарахгүй.*

Тухайлбал аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Цагдаагийн амралтын танхим, зоорийн давхрын засварт 14.0 сая, Дархан сумын ОНХС-аас зөөврийн нойлыг нүүлгэн шилжүүлэхэд 5.0 сая, Авто тээврийн төвд хүлээлгийн танхимын сандал худалдан авахад 5.0 сая, 2018 онд Агроэкологи бизнесийн сургуулийн багш нарын бичсэн фермийн төслийн төлбөрт 2.6 сая, Хонгор сумын ОНХС-аас сумын цагдаагийн байцаалт авах өрөөний засвар, явуулын кубон худалдан авахад 6.7 сая, нийт 33.3 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4[26], 60.3.6[27], Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.3[28], 4.7.5[29]-д заасантай нийцэхгүй байна.

Мөн сангийн хөрөнгөөр 2021 онд авто замын барилга, засварын 11 ТАХ хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 2,444.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд авто замын норм, нормативын санд 7.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 5.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Энэ нь ЗТХС-ын 2019 оны 256 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНбД 81-013-2019”-ын 5.4.8[30]-д заасантай нийцэхгүй байна.

Энэ нь ажил хариуцсан албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдал болон өөр ажилд шилжсэн, сангийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрхийн актын талаар мэдлэг мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотой байна.

Харин 2021 онд иргэдийн оролцоотой хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд Дархан сум 10 ТАХ-нд 74.0 сая, Хонгор сум 3 ТАХ-нд 33.7 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна. Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд иргэдийн оролцоог хангаснаар санхүүжилтийн тодорхой хэсгийг иргэдээс бүрдүүлэх, ингэснээр төсвийн ачаалал буурах, иргэдийн хяналт, оролцоо нэмэгдэх, төсөл үр дүнтэй хэрэгжихэд тодорхой нөлөө үзүүлж байна гэж дүгнэлээ.

### *2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 78.3 хувийн гүйцэтгэлтэй байна*

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд 8,360.1 сая төгрөгийн 143 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 101, дутуу хэрэгжсэн 11 байна. Бүрэн хэрэгжүүлсэн ТАХ-ээс 99 нь төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрч, 2 нь зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна гэж дүгнэлээ. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Дархан сумын 10 дугаар багт иргэн С.Баянмөнхийн гүйцэтгэсэн 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гадна зам талбайн тохижилт,
- Орхон сумын ОНХС-ийн хөрөнгөөр “Билигт инженеринг” ХХК-ны гүйцэтгэсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орхон сумын 11 км авто зам засварын ажил байна.

---

[26] *нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;*
[27] *орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.*
[28] *нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;*
[29] *орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ*
[30] *Авто замын барилга, засварын ажилд барилга угсралтын ажлын дүнгээс 0.4 хувиар тооцон нэгдсэн төсвийн тооцоонд тусгаж, авто замын норм нормативын санд төвлөрүүлнэ.*

Дээрх 2 төсөл арга хэмжээ зургийн дагуу хийгдсэн боловч чанар, ашиглалтын шаардлага хангахгүй, эвдрэл, гэмтэл үүссэн байна.

Иймд бүрэн хэрэгжүүлсэн 101 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зорилтот түвшин 98 хувийн гүйцэтгэлтэй, бүрэн болон дутуу хэрэгсэн гүйцэтгэлтэй нийт 112 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн зорилтот түвшинтэй харьцуулахад 78.3 хувийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэлээ.

Дээрх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд ОНХС-аас 5,108.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд үр өгөөж хүртэгчийн тоог 58,860 гэж тооцоолжээ.

Тухайн жилд хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүндээ хүрч чадахгүй байгаад худалдан авах ажиллагаа амжилтгүй болох, гүйцэтгэгч гэрээний хугацааг мөрдөж ажиллаагүй байх, цар тахал, хил гаалийн хориг, захиалагчийн хяналт зэрэг олон хүчин зүйл нөлөөлжээ.

### *2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр сум, орон нутгийн хөгжилд үр дүнгээ өгөх ТАХ-г хэрэгжүүлсэн байна*

ОНХС-ийн сангийн хөрөнгөөр 2021 онд нийт 112 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ хэрэгжүүлэхэд 5,108.0 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 79.7 хувь буюу 4,073.5 сая төгрөгийг авто замын засвар шинэчлэлт, орчны тохижилт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, дэд бүтэц татах, машин тоног төхөөрөмж, малын үүлдэр угсаа сайжруулах, усан хангамжийн эх үүсвэрийг хамгаалах зэрэг орон нутгийн хөгжилд бодитой үр дүн үзүүлэх төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.

Хэрэгжсэн ТАХ-ээс онцолбол Хонгор сумын ОНХС-ийн хөрөнгөөр ашиг шим өндөртэй цэвэр үүлдрийн 40 хуц, 30 ухна худалдан авахад 25.0 сая төгрөг зарцуулсан байна. Хонгор сум нь аймгийн нийт газар нутгийн 77 хувийг эзэлдэг, 253.3 га нутаг дэвсгэртэй, газар тариалангийн бүс нутаг бөгөөд статистик мэдээгээр нийт малын тоо, толгойн 64.4 хувь буюу 228,704 нь тус суманд байдаг гэсэн тоон мэдээ байна. Үүний 192,293 нь бог мал эзэлж байгаа бөгөөд бэлчээрийн доройтолд хүргэдэг гол хүчин зүйлүүдийн нэг нь ямаа юм. Иймд малын тоо толгойн өсөлтөд бус ашиг, шим өндөртэй цөөн тооны малтай байх нь малчдын болоод сумын эдийн засаг, байгаль орчин зэрэгт үр дүнгээ өгсөн ТАХ болжээ. Мөн 225.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хүнсний ногооны дундын аж ахуйд техник, багаж тоног төхөөрөмж худалдан авсан нь техник, тоног төхөөрөмжгүй хүнсний ногоо тариалагчдад бага зардлаар үйлчилгээ үзүүлэх, ингэснээр өрхийн орлого нэмэгдэх, сум тодорхой хэмжээний орлогын эх үүсвэртэй болох нөхцөл бүрджээ.

**Дүрслэл 2:** Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ангилж үзүүлэв




Дүрслэлээс харахад бага төсөвтэй, жижиг төсөл арга хэмжээнд 189.9 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж, ширээ сандал худалдан авах, урсгал засвар хийх зэрэг төсөл, арга хэмжээг санхүүжүүлжээ.

### *2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон зарим хөрөнгө эвдэрч, шаардлага хангахааргүй болжээ*

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгө тухайн орон нутгийн иргэд, олон нийт, эзэмшигч, ашиглагч байгууллагын шаардлагад нийцэж, ашиглалт хэвийн байгаа эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

***Аймгийн ОНХС:***

- Дархан сумын 10 дугаар багийн байрны гаднах зам талбайн тохижилтын ажлын хүүхдийн тоглоом эвдэрч хэрэгцээ, чанарын шаардлага хангахгүй болсон. Гүйцэтгэгч: Иргэн С.Баянмөнх, төсөвт өртөг-19.9/





***Орхон сумын ОНХС:***

- Төв замаас Орхон сумын төв хүртэлх 11 км авто замын засвар, нөхөөсний ажлын ихэнх хэсэгт эвдрэл үүссэн.
  /Гүйцэтгэгч: “Билигт инженеринг” ХХК, ХХКТөсөвт өртөг-20.0 сая/




Дээрх 2 төсөл, арга хэмжээнээс бусад хөрөнгийн ашиглалт хэвийн байна.

***2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг зориулалтын агуулахад хадгалаагүйгээс эвдрэл, гэмтэл үүсэх, алдагдах эрсдэлтэй байна***

ОНХС-ийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байгаа эсэхийг тухайн хөрөнгийг эзэмшигч байгууллага, ААН-ийг хамруулан шалгахад зарим хөрөнгийг зориулалтын байр, агуулахад хадгалаагүй байна.



Тухайлбал аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн тохижилтын ажлын сандал, хогийн сав, хашааны тор зэргийг НААҮГ-ын хашаанд хураасан байна.

Энэ нь тухайн хөрөнгөд эвдрэл, гэмтэл, зэврэлт үүсэх, алдагдах эрсдэлийг бий болгож байна. Иймд дээрх хөрөнгийг зориулалтын байр, агуулахад хадгалах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 3. Захиалагчийн хяналт сул байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж байна

### *3.1.1. Аймаг, сумын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.*

Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4[31]-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо хяналт тавихаар заасны дагуу хяналт тавьж ажилласан байна.

Тодруулбал аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хороодын хурлын баримт материалтай танилцахад хяналтын хороод 2021 онд төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа болон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахаар ажлын төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлж ажилласан байна.

### *3.1.2. Захиалагчийн хяналт сул байгаагаас зарим хөрөнгө оруулалтын ажлууд зураг, төсвийн дагуу, чанартай хийгдээгүй байна*

ТБОНӨХБАУХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6[32]-д заасны дагуу захиалагч нь гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, мөн Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар зохицуулжээ.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ хуульд заасан эрх, үүргийн хүрээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх гэрээг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-тай байгуулж, тус гэрээний дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт хэрэгжүүлжээ.

Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т хүргүүлж, гүйцэтгэлийг хянаж баталгаажуулснаар санхүүжилтийг олгосон байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд

- Дархан сумын 9, 10, 11, 12 дугаар багийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэгч “Ингүүмэл эрчим” ХХК нь гэрлийн шонгийн суурийг зураг, төсвийн дагуу зориулалтын бетон сууриар хийгээгүй.

---

*[31] ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.*

*[32] гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;*

- Шинэ хуучин Дарханыг холбосон авто замаас 27 дугаар байрны дэргэдэх дөрвөн замын уулзвар хүртэлх авто зам дагуух гэрэлтүүлгийн ажлын гэрлийн шонд тэгшилгээ хийхдээ сууринд эвээс хийсэн.
- Дархан сумын 10 дугаар багийн гадна зам талбайн тохижилтын ажлаар хийгдсэн хүүхдийн тоглоом эвдэрсэн.
- Төв замаас Орхон сумын төв хүртэлх 11 км засмал зам засварын ажлын нөхөөс ихэнх хэсэгтээ эвдэрсэн, өөр ажлын материалын шинжилгээний бичиг хавсаргасан зөрчилтэй

Дээрх зөрчлүүд нь “ДХББЗГ” ОНӨААТҮГ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх гэрээний 3.4-д *“Барилгад хэрэглэх материалуудын чанарын сертификатыг шалгаж, хийц бүтээцүүдийн дээжийг итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж баталгаажуулах”*, 3.6-д *“Гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг зураг төсөлд заагдсан төсвийн норм, үнэлгээ, үнэ тарифын дагуу хянаж баталгаажуулах”*, 3.8-д *“Чанаргүй, эсхүл дутуу гүйцэтгэсэн зөрчил, дутагдалтай барилгын ажлын талаар дүгнэлт гаргах, тогтоосон хугацаанд засуулах, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээг авах ажлыг ерөнхий захиалагчид тухай бүр танилцуулах”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Энэ нь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанарын шаардлага хангахгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах зэрэг эрсдэлтэй.

### *3.1.3. Өмнөх аудитын шалгалтаар илэрсэн алдаа зөрчил давтагдан гарч, зөрчлийн хэмжээ буурахгүй байна*

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас ОНХС-ийн 2020 оны үйл ажиллагаанд гүйцэтгэл, нийцлийн аудит хийгдээгүй бөгөөд энэ аудитаар 2020, 2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн алдаа зөрчил давтагдаж байгаа эсэхийг тулгахад алдаа, зөрчлийн тоо өссөн байна.

**Дүрслэл 3:** Алдаа, зөрчлийн өсөлтийг ангилж харуулав.




Дээрх дүрслэлээс үзэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарсан

байна. Үүнд ОНХС хариуцсан ажилтан өөр ажилд шилжих, албан тушаалтны хариуцлагагүй байдал нөлөөлжээ.

ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжээс Орхон, Хонгор сумдын ОНХС-ийн 2019, 2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж чанарын баталгаат хугацаанд эвдрэл, гэмтэл гарсныг засварлуулах 3, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах 2, төсвийн төлөвлөгөө, журмын хэрэгжилттэй холбоотой 3, нийт 8 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.

Цаашид төсөв захирагч нар хөндлөнгийн болон дотоод аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

### *3.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу хугацаанд нь тайлагнажээ*

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.2[33], 9.9[34]-д заасны дагуу холбогдох байгууллагуудад, заасан хугацаанд тайлан, мэдээг хүргүүлж ажилласан байна.

Аудитаар аймаг, сумдын ОНХС-ийн гүйцэтгэл, зарцуулалтыг журамд заасны дагуу тайлагнасан эсэхийг хянахад сумдын ЗДТГ-аас ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т, аймгийн ЗДТГ-аас ОНХС-ийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд тус тус журамд заасан хугацаанд хүргүүлжээ.

